

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна



Гидеоны
бяцхан
арми



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest

Найруулсан: Ruth Klassen


Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2015 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**





**Иошуаг нас
барснаас хойш
Израилийн ард
түмэн Бурханд
гомдоллож Бурханаас
холджээ. Бурхан
тэднийг хөрш болох
Мидианчуудын
гарч тушааж**

**тэд Израилийн гэр
орон болон ургацыг
хоосруулдаг байв.**



**Гидеон гэдэг нэгэн Израил
хөвгүүн ургацаа хадгалдаг
нууц газартай байв. Тэр том
модны доор усан үзмийн
шахуурга дотор
будаагаа**


**цайруулдаг
байжээ.**




Мидианчууд тэр газрыг
нь мэдэхгүй ч Бурхан
мэдэж байлаа. Бурхан
тэнгэр элчээ Гидеон
уруу илгээв.



**Бурхан Гидеоныг эцэг өвгөдийнхөө шүтэж байсан
хуурамч шүтээнүүдийг устгаж жинхэнэ Бурханд
зориулж тахилын ширээ босго хэмээн хэлжээ.
Гидеон нутгийн иргэд үүнийг хийвэл түүнийг алах
бий хэмээн айж байсан ч Бурханы тушааснаар
хийжээ.**



**Бурхан мөн түүнийг Мидианы эсрэг тулалдаанд
Израилийн цэргүүдийг удирдахыг хүсэв. Гэвч
Гидеон айж байлаа. Тэр Бурханаас Тэр түүнтэй хамт
байх уу хэмээн тэмдэг үзүүлэхийг хүсэв. Тэгээд тэр
хэсэг ноосыг авч газар тавив.**





**"Хэрэв зөвхөн тэр
ноосон дээр л
шүүдэр бууж,
хамаг газар
хуурай
байвал, Та
амласан
ёсоор
надаар
дамжуулан**


**Израилийг аврах
болно гэдгийг чинь би
мэдье" хэмээн Гидеон залбирав.**

**Өглөө болоход газар нь хуурай ч харин
НООС НЭВТ НОРСОН БАЙВ!**



Гэсэн ч Гидеон эргэлзсээр
байлаа. Харин энэ удаад
тэр Бурханаас зөвхөн ноосыг
хуурай байлгаж, эргэн тойронд
нь шүүдэр буулгаж өгхийг гуйв.

Дараа өдрийн өглөө газар дээр
шүүдэр бууж харин **НООС**
ХУУРАЙ
БАЙВ!




Гидеон 32,000 цэргээ аван гарав. Бурхан түүний цэргээс хасаж 300 болголоо. Бид өөрсдийн хүчээр Израилыг аварлаа гэж ярих бий гэсэн дээ Бурхан ийнхүү хийжээ. Зөвхөн Бурхан л тэдний цорын ганц аврагч байв.


~~32,000~~

~~10,000~~

300




Бурхан Гидеоныг айсан хэвээр байгааг мэдээд түүнийг Мидианы нэгэн цэрэг зүүдээ нөгөөдөө ярьж байхыг сонсох боломжийг өгчээ. Түүний зүүдэнд нэгэн талх мидианчуудын хуаранд өнхөрч ирээд, майханд хүрч мөргөсөнд майхан нурж унасан гэв.




Нөгөөх сонсож суусан харуул "Энэ чинь Гидеоны илднээс гарцаагүй" хэмээн хашхирав. Гидеон зүүд болон тайллыг нь сонсоод Бурхан түүнд ялалтыг өгнө гэдгийг мэдэв.




Тэгээд Гидеон шөнөөр дайрахаар төлөвлөжээ. Тэр цэрэг бүрт бүрээ болон хоосон саванд бамбар хийн өгөв. Тэд Мидианы цэргийн хуаранг тойрон байрлав.




Гидеоны дохиогоор цэргүүд бүрээгээ үлээж, саваа цохиж мөн бамбараа асаав. Бөөн шуугиан! Бөөн бужигнаан! Мидианчууд босон зугтацгаажээ.



**Энэ агуу ялалтын дараа, Израилийн хүмүүс
Гидеоныг өөрсдийн удирдагч болохыг хүсэв.**



**Гэтэл Гидеон "Би та нарыг удирдахгүй Эзэн та
бүхнийг удирдах болно" гэв. Тэр зөвхөн Бурхан л
хүмүүсийн амьдралыг зөв удирдаж чадна гэдгийг
мэдэж байв.**



Гидеоны бяцхан арми

Бурханы үг Библиээс авсан түүх

Шүүгчид 6-8

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

